

УДИРТГАЛ

Эмийн үндэсний бодлого нь хүн амыг өндөр идэвхтэй, чанарын баталгаатай, эмийн бүртгэлд бүртгэгдсэн эмээр тасралтгүй, хүртээмжтэй, жигд хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэдэг.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн төлбөрийг төр хариуцаж иргэнд үнэ төлбөргүйгээр олгох асуудал нь Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2012 оны 129/100 тоот хамтарсан тушаалд заасны дагуу зохицуулагддаг ба өвчиний нэрс болон эмийн жагсаалтыг энэхүү журмын хоёр дугаар хавсралтаар баталсан.

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэгдэх өвчнүүдийн эмийн нэр төрөл, тоо хэмжээг тодорхойлон гаргаж, тухайн эмээр тасралтгүй жигд хүртээмжтэй хангах талаар маркетингийн судалгааны аргуудыг ашиглан хийгдсэн судалгаа хомс байгаа ба мөрдөгдөж буй төлбөргүй тусламж үйлчилгээний журамд орсон үнэгүй олгогддог эмүүд нь өвчтөндөө хир хүртээмжтэй байгааг нягтлан үзэх зайлшгүй шаардлага байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болсон юм.

Судалгаа, нийтлэлийн зорилго:

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчнүүдэд хэрэглэгдэж буй эмийн хэрэгцээг Улаанбаатар хотоос сонгогдсон дүүргийн нэгдсэн эмнэлэг тус бүрээр тооцож шаардагдах төсөв хөрөнгийг тодорхойлох үндсэн зорилгыг тавилаа.

Судалгааны материал, аргазүй:

1. Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв /СДЭМТ/, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв /ЧЭМТ/, Налайх дүүргийн эрүүл мэндийн төв/НАЭМТ/-ийн амбулаториор үнэ төлбөргүй олгосон эмийн тайлан, бүртгэлийн архивын материал ашиглан тусгай картын дагуу эмийн нэр төрөл, тун хэмжээ, үнийн дүнгээр судлах
2. Үнэ төлбөргүй олгогдож буй эмийн зардал, түүний хувиарлалтын ЭМСЯ-ны санхүү, эдийн засгийн тайлан мэдээ
3. Сүрьеэ, хорт хавдрын гурав, дөрөвдүгээр ve шат (хөнгөвчлөх эмчилгээ), сэтгэцийн эмгэг, удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэг үүнд нь чихрийн шижин, чихрийн бус шижин, бамбай булчирхайн дутмагшил, өнчин тархины шалтгаант өсөлтийн дааврын дутмагшил, паркинсоны өвчин, уналт таталт (Эпилепси), миастени, нүдний даралт ихсэх өвчин (Глаукома), эрхтэн шилжүүлж суулгасны дараах байдал, дархлалын олдмол хомсдол өвчин, гемофилии зэрэг оноштой, 100 өвчний түүх, амбулаторийн хяналтын картын материалууд болон жоронд бичигдсэн эмийн хэрэглээний судалгаа

Судалгааны үр дүн:

ТТХАЭӨ-ний жагсаалтанд орсон 14 өвчиний 41 нэр төрлийн эм байгаа ба өвчин тус бүрийн эмүүдийн эзлэх хувийг тооцон гаргалаа. (Зураг 1)



Амбулаториор үнэ төлбөргүй олгодог эмүүдийн судалгаа-2015 он

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчний эмчилгээнд хамгийн олон болох 28.57% буюу 14-н нэр төрлийн сүрьеэгийн эм бэлдмэл, 18,036% буюу 9-н нэр төрлийн сэтгэцийн эмгэгийн эм бэлдмэл, 14.28% буюу 7-н нэр төрлийн хорт хавдарын III, IV-р үеийн хөнгөвчлөл эмчилгээний эм бэлдмэл, 10.20% буюу 5-н нэр төрлийн чихрийн шижиний эм бэлдмэл жагсаалтанд орсон байна.

2012-2014 онд Улаанбаатар хотын СДЭМТ, НАЭМТ, ЧЭМТ-ийн төлбөрийг нь төр хариуцдаг өвчин эмгэгтэй иргэнд амбулаториор үнэ төлбөргүй эм олгогдсон судалгааг хүснэгт 1-ээр харуулав.

№	Өвчний нэр	2012			2013			2014			Нийт өвчлөлийн тоо өвчин тус бүрээр
		СДЭМТ	ЧЭМТ	НАЭМТ	СДЭМТ	ЧЭМТ	НАЭМТ	СДЭМТ	ЧЭМТ	НАЭМТ	
1	Сүрьеэ	1134	1323	-	1034	1376	-	1400	1402	-	7669
2	Хорт хавдрын гурав, дөрөвдүгээр үе шат (хөнгөвчлөл эмчилгээ)	846	36	88	1009	55	98	1400	63	77	3672
3	Сэтгэцийн эмгэг	-	25	-	-	50	-	-	54	37	166
4	Чихрийн шижин	1096	381	110	1100	500	118	1349	595	123	5372
5	Чихрийн бус шижин	28	14	-	30	18	6	28	20	6	150
6	Бамбай булчирхай	26	15	-	28	29	3	28	30	-	159
7	Өнчин тархины шалтгаант осолтийн дааварын	13	-	-	13	-	-	12	-	-	38
8	Паркинсоны өвчин	-	25	-	-	32	12	-	35	-	104
9	Уналт таталт (Эпилепси)	-	11	-	-	20	20	-	20	20	91
10	Миастени	-	-	-	-	-	-	-	10	-	10
11	Нүдний даралт ихсэх өвчин	-	20	-	-	21	15	-	40	15	111
12	Эрхэн шилжүүлэн суулгасны	-	-	-	-	-	-	-	-	-	0
13	Дархалын олдмол хөмсгөл өвчин	-	5	-	-	8	-	-	11	-	24
14	Гемофилий	-	-	-	-	-	-	-	-	-	0
Нийт өвчлөлийн тоо он тус бүрээр		3143	1855	198	3214	2109	272	4217	2280	278	17566

Хүснэгт 1: Түүвэрлэн судалсан эмнэлгүүдийн өвчлөлийн байдлийг гурван жилийн хугацаанд ТТХАЭӨ-ний журмын дагуу үйлчлүүлсэн байдлаас үзэхэд СДЭМТ-д нийт 10574 өвчтөн, ЧЭМТ-д 6344 өвчтөн, НАЭМТ-д 748 өвчтөн тус тус үйлчлүүлсэн ба нийт гурван дүүргийн хэмжээнд 17566 өвчтөнд амбулаториор үнэ төлбөргүйгээр эм олгогдсон байна.

2012-2014 онд Улаанбаатар хотын СДЭМТ, НАЭМТ, ЧЭМТ-ийн төлбөрийг нь төр хариуцдаг өвчин эмгэгтэй иргэнд амбулаториор үнэ төлбөргүй олгогдсон эмийн мөнгөн дүнгийн судалгааг хүснэгт 2-ээр харуулав.

Өвчний нэр	СДЭМТ			ЧЭМТ			НАЭМТ			Нийт мөнгөн дүн өвчлөл тус бүрээр
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014	
Сүрьеэ	-	-	-	MNT 24,956,463	MNT 25,512,485	MNT 26,078,619	-	MNT 910,000	MNT 980,000	MNT 78,437,568
Хөнгөвчлөл эмчилгээ	MNT 5,742,869	MNT 20,739,139	MNT 29,712,309	MNT 28,005,398	MNT 28,307,500	MNT 29,859,600	MNT 25,216,420	MNT 34,172,240	MNT 36,135,240	MNT 237,890,715
Сэтгэцийн эмгэг	-	-	MNT 431,552	MNT 251,276	MNT 1,007,300	MNT 948,300	-	MNT 338,800	MNT 12,694,440	MNT 15,671,668
Чихрийн шижин	MNT 31,080,310	MNT 29,621,680	MNT 52,071,958	MNT 55,311,250	MNT 75,315,000	MNT 88,701,000	MNT 20,769,960	MNT 22,272,240	MNT 23,026,640	MNT 398,170,038
Чихрийн бус шижин	MNT 3,600,000	MNT 3,950,000	MNT 16,800,000	MNT 12,480,000	MNT 19,200,000	MNT 24,000,000	-	MNT 4,320,000	MNT 4,320,000	MNT 88,670,000
Бамбай булчирхай	MNT 68,160	MNT 136,000	MNT 164,750	MNT 598,260	MNT 990,000	MNT 1,080,000	-	-	-	MNT 3,037,170
Өнчин тархины шалтгаант осолтийн дааварын	-	-	-	-	-	-	-	-	-	-
Паркинсоны өвчин	MNT 1,734,400	MNT 1,024,000	MNT 5,518,700	MNT 840,000	MNT 12,249,600	MNT 12,800,000	-	MNT 570,240	-	MNT 34,736,940
Уналт таталт (Эпилепси)	-	-	-	MNT 5,984,030	MNT 10,396,000	MNT 13,704,000	-	MNT 522,720	MNT 493,680	MNT 31,100,430
Миастени	-	-	-	-	-	MNT 12,000	-	-	-	MNT 12,000
Нүдний даралт ихсэх өвчин	-	-	-	MNT 97,800	MNT 169,400	MNT 686,400	-	MNT 565,488	MNT 323,400	MNT 1,842,488
Эрхэн шилжүүлэн суулгасны	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дархалын олдмол хөмсгөл өвчин	-	-	-	MNT 116,226	MNT 154,000	MNT 198,000	-	-	-	MNT 468,226
Гемофилий	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт зарцуулагдсан төсөв	MNT 42,225,739	MNT 55,470,819	MNT 104,699,269	MNT 128,640,703.9	MNT 173,301,285.2	MNT 198,067,919.02	MNT 45,986,380	MNT 63,671,728	MNT 77,973,400	MNT 890,037,243.12

Хүснэгт 2: Хүснэгтээс харахад 2012, 2013, 2014 оны байдлаар нийт 17566 хүн төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд хамрагдаж, эмнэлгийн амбулаториор үнэ төлбөргүйгээр 890,037,243.12 төгрөгний эм хэрэглэсэн байна.

ДҮГНЭЛТ

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчний эмчилгээний жагсаалтанд сүрьеэ, сэтгэцийн эмгэг, хорт хавдарын III, IV-р үеийн хөнгөвчлөл эмчилгээ, чихрийн шижин зэрэг 14-н өвчний үеийн 41 нэр төрлийн эм бэлдмэлүүд орсон байна.

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчнийг судалгаанд хамруулсан эмнэлгүүдэд сүүлийн гурван жилээр авч үзэхэд нийт 17566 өвчтөн эмчлэгдэж, үнэ төлбөргүйгээр 890,037,243.12 төгрөгний эм олгосон байна.

Харин эрхтэн шилжүүлэн суулгасны дараах болон гемофилийн эсрэг эмчилгээ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

Дээрх судалгааны үр дүнд үндэслэн төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэгдэх өвчнүүдийн нийт эмийн төсвийг тооцон, эрэлт хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай эмээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, улсын төсөв хөрөнгийг үр ашигтай зарцуулах боломжийг бий болгохын тулд энэхүү судалгааны ажил үргэлжилж байна.